



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар
хот

Нийслэлийн нийтийн тээвэрт байгаль
орчинд ээлтэй, цахилгаан автобус
нэвтрүүлэх туршилт хийх тухай

Автотээврийн тухай хуулийн 5.1.1, 9.4, Инновацийн тухай хуулийн 17.1.8, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд байгаль орчинд ээлтэй “МОН-30” загварын том оврын цахилгаан автобус 2 ширхэгийг дотоодын үйлдвэрлэгчид захиалан үйлдвэрлүүлж, нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх туршилт хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт даалгасугай.

2. “МОН-30” загварын том оврын цахилгаан автобус захиалж үйлдвэрлүүлэхэд шаардагдах 939.444.000 (есөн зуун гучин есөн сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ч.ХҮРЭЛБААТАР

